

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 3990.1 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 9.2 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2033.0 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 6.5 хувиар давж биелсэн боловч Мөнххаан 4.2 хувь, Баруун-Урт 16.3 хувиар тус тус тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 2267.1 сая төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 1385.6 сая төгрөгөөр доогуур байна. Баруун-Урт 6.4 хувь, Түмэнцогт 12.1 хувиар тус тус хэтэрсэн гүйцэтгэлтэй байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 12.7 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 253.3 сая төгрөгөөр буурсан байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 10.8 тэрбум төгрөг болсон нь 2009 оны жилийн эцсээс 3.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 0.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 79.7 хувь болох 617.3 мянган эх мал төллөж, гарсан төлийн 97.6 хувь болох 608.9 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Оны эхний малын 1.4 хувь болох 24.6 мянган мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 4.3 дахин олон байна.

Түмэнцогт суманд оны эхний малын 7.7 хувь нь зүй бусаар хорогдоод байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж, МИДаатгалд хамрагдсан малчид нөхөн төлбөр авах болж байна.

Газар тариалан: Эхний 5 сарын байдлаар үр тариа 50 га-д, төмс 43.4 га-д, хүнсний ногоо 15.5 га-д, тэжээлийн ургамал 9.7 га-д тус тус тариалалт хийгээд байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 12.4 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 1.3 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 53.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 3.3 дахин дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс цайрын баяжмал, блокын үйлдвэрлэлт доогуур байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 4-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 9.7 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 20.6 хувиар, түүн дотроо хүнсний бараа 21.3 хувь, үүнээс мах махан бүтээгдэхүүний үнэ 82.1 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 18.0 хувь, жимс, жимсгэнэ 42.0 хувь, хүнсний ногоо 40.8 хувиар тус тус өссөн байна.

Тэвэрээс бусад бүлгийн үнэ өссөний дотор гэр ахуйн бараа-ны бүлгийн үнэ 1.0 хувь, орон сууц, цахилгаан, хийн болон бусад түлшний тариф 1.0 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 1.1 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний тариф 2.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ тариф 2.3 хувь, холбооны тариф 31.3 хувиар тус тус өсч, боловсрол, нийтийн хоол, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний үнэ, тариф тогтвортой байлаа.

VII. ЭРҮҮЛ МЭНД: 490 эх амаржсан байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13 болж урьд оны мөн үеэс 8-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 235 болж, урьд оны мөн үеэс 99-өөр доогуур байна. Вируст гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихомоноз зэрэг өвчнүүд буурсан байна.

VIII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1236 болж, урьд оны мөн үеийнхээс 128 хүнээр нэмэгдсэн байна. Ажилгүйчүүдийн 67.2 хувь нь 16-34 насны залуучууд, 17.1 хувь нь дээд, 4.4 хувь нь тусгай дунд, 37.3 хувь нь бүрэн дунд, 7.8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

805 хүн шинээр бүртгүүлж, 589 хүн ажилд орсон байна.

Шинэ ажлын байранд ажиллаж байгаа хүний тоо 166-т хүрчээ.

IX. ГЭМТ ХЭРЭГ: 75 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14-өөр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 19 хүн нас барж, 15 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 28.3 сая төгрөгийн хохирол учирсны 19.9 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 77 хүн холбогдон сэжиглэгдсэний 14.3 хувь нь согтуугаар, 16.9 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1073 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 90 хүнээр доогуур байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 58 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Хэрэг илрүүлэлт 93.1 хувьтай байна.

X. МАЛЫН ИНДЕСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: 2010 онд Сүхбаатар аймагт МИД төслийг хэрэгжүүлэх эрх авсан 4 даатгалын компаниуд 06 сарын 03-ны байдлаар 8 сумын 51 өрхийн 16.1 мянган толгой малыг 6.9 сая төгрөгөөр даатгалд хамруулсан байна.

XI. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ: 2010 оны 06 сарын 04 байдлаар ХХААЖДҮГ дээр 1942.2 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 102 төсөл ирсэнээс дэд комиссын 4 удаагийн хурлаар хэлэлцэн 1135.0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 65 төслийг шалгаруулаад харилцагч банканд хүргүүлсэн.

Харилцагч банк одоогоор сумдын 33 төслийн 472.6 сая төгрөгийн санхүүжилт хийгээд байна.